



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/333

Улаанбаатар хот

### Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Хөрөнгө бүртгэн авах тухай” 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, төсөл, хөтөлбөр, хандивын хөрөнгөөр Налайх, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон, нийт 655,084,064.98 (зургаан зуун тавин таван сая наян дөрвөн мянга жаран дөрвөн төгрөг ерэн найман мөнгө) төгрөгийн өртөг бүхий, хавсралтад заасан 11 ус түгээх байрыг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2.Нийслэлийн өмчид шинээр бүртгэгдэж байгаа барилга байгууламжуудыг данс бүртгэлдээ бүртгэн авч, ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ (Ц.Төрхүү), “Чандмань налайх” ОНӨААТҮГ (З.Болдбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



1110201465

Нийслэлийн Засаг даргын 2023 оны  
 04 сарын 03-ны өдрийн  
 захирамжийн  
 хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Бүртгэх үнэ (төгрөгөөр)	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Бүртгэх байгууллага
1	Ус түгээх байр	Сонгинохайрхан дүүргийн 31 дүгээр хороо	2021	58,638,964.00	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө	“Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ
2	Ус түгээх байр	Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороо	2022	59,917,151.00		“Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ
3	Ус түгээх байр-3	Налайх дүүргийн 8 дугаар хороо Нарлаг-5 гудамж	2022	55,816,304.33	Япон улсын буцалтгүй тусламж Өвсний үндэс хүний аюулгүй байдлыг хангах төслийн хандивын хөрөнгөөр	“Чандмань Налайх” ОНӨААТҮГ газар
4	Ус түгээх байр-4	Налайх дүүргийн 1 дүгээр хороо Уурхайчид-10 гудамж	2022	55,816,304.33		“Чандмань Налайх” ОНӨААТҮГ газар
5	Ус түгээх байр-17	Налайх дүүргийн 4 дүгээр хороо Нисэх-16 гудамж	2022	55,816,304.33		“Чандмань Налайх” ОНӨААТҮГ газар
6	Ус түгээх байр-19	Налайх дүүргийн 7 дугаар хороо Бадралын -13 гудамж	2022	55,816,304.33		“Чандмань Налайх” ОНӨААТҮГ газар
7	Ус түгээх байр-20	Налайх дүүргийн 4 дүгээр хороо Өлгийн-6 гудамж	2022	55,816,304.33		“Чандмань Налайх” ОНӨААТҮГ газар
8	Ус түгээх байр-24	Налайх дүүргийн 3 дугаар хороо Дэнжийн склад хажууд	2022	55,816,304.33		“Чандмань Налайх” ОНӨААТҮГ газар
9	Ус түгээх байр-12	Налайх дүүргийн 3 дугаар хороо Наран-26 гудамж	2022	79,157,435.00		Дээрэт олон улсын энэрлийн байгууллагын хөрөнгөөр
10	Ус түгээх байр-37	Налайх дүүргийн 7 дугаар хороо Өвөршандын-ба гудамж	2022	79,157,435.00	Дээрэт олон улсын энэрлийн байгууллага	“Чандмань Налайх” ОНӨААТҮГ газар
11	Ус түгээх байр-35	Налайх дүүргийн 4 дүгээр хороо Нисэхийн 526 гудамж	2022	43,315,254.00	Тайваны хүүхэд гэр бүлийг дэмжих сан	“Чандмань Налайх” ОНӨААТҮГ газар
	Нийт дүн			655,084,064.98		